**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 09 өдөр Дугаар А/856 Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс
хөрөнгө хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй нийт 37,200,030.92 (гучин долоон сая хоёр зуун мянга гучин төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 12,494,214.36 (арван хоёр сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун арван дөрвөн төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй хавсралтад заасан гүний худгийн 2 ширхэг барилга, ус түгээх 6 ширхэг байрыг тус тус акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т зөвшөөрсүгэй.

2.Акталж, данс бүртгэлээс хасагдаж буй барилгыг буулгах, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах боломжтой түүхий эд материалыг үнэлэн худалдаж, худалдсанаас орох орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ (Т.Вандандорж)-т даалгасугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

1110204030

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 09 өдрийн А/856 дугаар захирамжийн хавсралт

/тегрөгөөр/

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| № | Эд хөрөнгийн нэр | Байршил | Ашигласан жил | Нийт үнэ | Хуримтлагд-сан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Мэргэжлийн Улсын байцаагчийн дүгнэлт, шалтгаан | Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Гүний худгийн барилга -Үйлдвэрийн эх үүсвэрийн 6-р худаг" | Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо | 61 | 2,918,271.09 | 2,918,271.09 | 0.00 | Хотын стандарт, хяналтын газрын Улсын байцаагчийн 2023.12.20-ны өдрийн 02-13-01-033/207 тоот дүгнэлтээр тоосгон хана элэгдэж, үйрсэн, шавардлага нь хөндийрсөн дээврийн хучлагаас хурын ус нэвчсэн дотор хана тааз чийгтэж цантсан хаяавч бетон эвдэрсэн, барилгын стандарт шаардлагыг хангахгүй болохыг тогтоосон. | 150,000.0 |
| 2 | "Гүний худгийн барилга -Үйлдвэрийн эх үүсвэрийн 7-р худаг" | Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо | 61 | 2,918,271.09 | 2,918,271.09 | 0.00 | Хотын стандарт, хяналтын газрын Улсын байцаагчийн 2023.12.20-ны өдрийн 02-13-01-033/207 тоот дүгнэлтээр тоосгон хана элэгдэж, үйрсэн, шавардлага нь хөндийрсөн дээврийн хучлагаас хурын ус нэвчсэн дотор хана тааз чийгтэж цантсан хаяавч бетон эвдэрсэн, барилгын стандарт шаардлагыг хангахгүй болохыг тогтоосон. | 150,000.0 |
| 3 | "Ус түгээх байр-281" | Сонгинохайрхан дүүрэг 24-р хороо | 11 | 6,247,296.73 | 2,732,139.15 | 3,515,157.58 | Тус ус түгээх байрыг СХД-ийн Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ААТҮГ-ын хог тээвэрлэх зориулалт бүхий том оврын авто машин хүч алдан гулгаж зүүн талаас нь мөргөн нураасан. СХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр СХД-ийн Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ААТҮГ-аас Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын нэхэмжилсэн 15,232,007.0 төгрөгийн хохирлыг барагдуулахаар шийдвэрлэгдсэн. Тус газар дээр дахин ус түгээх байр барихгүй зөөврийн контейнер байрлуулсан. | 150,000.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | "Ус түгээх байр-082" | Сүхбаатар дүүрэг 17-р хороо | 12 | 3,922,098.48 | 1,051,248.08 | 2,870,850.40 | "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн хүрээнд гүйцэтгэх Дамбадаржаа дэд төвийн Авто замын трасст тус үс түгээх байр орсон тул төслийн хүрээнд өөр газар шилжүүлэн барьж өгөхөөр болсон. | 150,000.0 |
| 5 | "Ус түгээх байр-277" | Сонгинохайрхан дүүрэг 9-р хороо | 13 | 2,778,838.57 | 992,442.60 | 1,786,395.97 | "Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл"-ийг хэрэгжүүлэхээр СХД-ийн 9-р хороонд гэр хорооллын 5.6 га газрыг чөлөөлж эко хороолол барих болсон. Энэ газрын трасст тус ус түгээх байр орсон тул буулгаж газрыг чөлөөлөх шаардлагатай болсон. | 150,000.0 |
| 6 | "Ус түгээх байр-610" | Баянгол дүүрэг 10-р хороо | 39 | 6,231,185.10 | 6,231,185.10 | 0.00 | Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2020.09.17-ны өдрийн 02-07-118/1341 тоот дүгнэлтээр барилгын стандарт шаардлагыг хангахгүй гэж дүгнэсэн. | 150,000.0 |
| 7 | "Ус түгээх байр-549" | Баянзүрх дүүрэг 23-р хороо | 11 | 5,118,947.94 | 4,068,630.90 | 1,050,317.04 | Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2021.04.06-ны өдрийн 02-07-136/253 тоот дүгнэлтээр барилгын стандарт шаардлагыг хангахгүй гэж дүгнэсэн. | 150,000.0 |
| 8 | "Ус түгээх байр-583" | Чингэлтэй дүүрэг 16-р хороо | 21 | 7,065,121.92 | 3,793,628.55 | 3,271,493.37 | Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2021.04.06-ны өдрийн 02-07-136/253 тоот дүгнэлтээр барилгын стандарт шаардлагыг хангахгүй гэж дүгнэсэн. | 150,000.0 |
| Нийт дүн | | | | 37,200,030.92 | 24,705,816.56 | 12,494,214.36 | | 1,200,000.0 |